

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	2
1.2. ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮСИЙН ТАНИЛЦУУЛГА	2
1.3. ТӨСЛИЙН БАЙРШИЛ	5
ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ	6
ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	12
ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	13
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	18
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	21
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	28
АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	30
АРВАН ХОЁР. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	31
БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДАЛ.....	32

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:	Гаалийн хяналтын талбай
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:	“Говийн алтан гулдмай” ХХК Улсын бүртгэлийн дугаар:1111005119 Регистрийн дугаар: 3618641
Хаяг:	Өмнөговь аймаг, Ханбогд сум, 5-р баг, Хайрхан баг, Цагаан хад, Утас/факс: 88118770

1.2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

“Гаалийн хяналтын талбай” нь нийт 10 га талбайтай.

- Нүүрс ачих буулгах талбай
- Ажилчдын суурин, оффисын байр, Сэлбэгийн дэлгүүр, ШТС, Авто засварын цэг

Нүүрс ачиж буулгах талбай:

“Говийн алтан гулдмай” ХХК нь 2012 онд Гадаад худалдаа явуулах зорилгоор байгуулагдсан ба одоо Гашуун сухайт боомтын Цагаан Хад гаалийн хяналтын бүсэд гаалийн хяналтын талбай байгуулах зорилгоор 10 га талбайг эзэмшин, нүүрс буулгаж, түр хадгалах, ачих, гаалийн хяналт хийх үйл ажиллагаа явуулж байна.

Эзэмшил талбай нь 900.000-1.700.000 тонн ачаа хүлээн авах хүчин чадалтай бөгөөд хоногт 50-100 автомашин хүлээж авах боломжтой.

Өдөрт 3500-7000 тн орчим, сард 70000-14000 тн нүүрс буулгаж, мөн тэр хэмжээний нүүрсийг ачиж, Гашуун сухайтын боомтоор нэвтрүүлнэ.

Хүснэгт 1. Хяналтын талбайн хүчин чадал

№	Үйлчилгээний нэр төрөл	Хэмжих нэгж	Хоногт ажиллах хүчин чадал	Жилд ажиллах хоног	Жилд ажиллах хүчин чадал
1	Нүүрс	тонн	3500-7000	245	857500-1715000
2	Машин	машин/хоног	50-100	245	12250-24500

1.3. ТӨСЛИЙН ТАЛБАЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ

Гаалийн хяналтын талбай нь одоогоор ажилчид байрлах зориулалттай кемпийн байр, харуулын байр, сэлбэгийн дэлгүүр, ШТС , авто засварын цэг зэргээс бүрдэнэ.

10 га талбайд:

- ✓ Орж гарах хаалга 0.4 га
- ✓ ШТС 0.2 га
- ✓ Харуулын байр 0.4 га
- ✓ Сэлбэгийн дэлгүүр 0.2 га
- ✓ Зам 0.8га
- ✓ Кемпийн байр 1.5 га
- ✓ Авто засварын цэг 0.22



Зураг 1. Талбайн одоогийн харагдах байдал /2022.05/

Хүснэгт 2. Ажилчдын бүтэц зохион байгуулалт

№	Албан тушаал	Ажилчдын тоо
1	Захирал	1
2	Талбайн эрхлэгч	1
3	ХАБЭА ажилтан	2
4	Талбайн зохицуулагч	2
5	Ковшийн оператор	6
6	Засварчин	4
7	Тогооч	2
8	Эмч	1
9	Харуул	2
10	Пүүний оператор	2
11	Гар буулгагч	4
12	Үйлчлэгч	1



Зураг 2. Ажилчдын байр болон хашаа

1.4. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1.4.1. Цахилгаан хангамж:

Төвийн эрчим хүчинд холбогдсон.

1.4.2. Усан хангамж

Гаалийн хяналтын талбайд нийт хамгийн ихдээ 25-30 хүн байрлаж ажиллах ба тэдгээрийн хоол үнд ахуйн хэрэглээний усыг төслийн талбайгаас 24 км зайд байрлах худгаас зөөврөөр хангаж байна.


1.5. ТӨСЛИЙН БАЙРШИЛ

“Гаалийн хяналтын талбай” нь Өмнөговь аймгийн Ханбогд сум нутаг дэвсгэр Цагаан хад хэмээх газарт сумын төвөөс зүүн урагш 70км, Гашуун Сүхайтын хилийн боомтоос 23 км-т байрлана.


“Говийн алтан гулдмай” ХХК нь Ханбогд сумын Засаг даргын 2018 оны 02 сарын 05-ны өдрийн А/34 тоот шийдвэрээр 4601008735 тоот нэгж талбарын дугаар бүхий 10га талбайг 15 жилийн хугацаатай гаалийн хяналтын талбайн зориулалтаар эзэмшихээр эрх авсан.

Хүснэгт 3. Талбайн эргэлтийн цэг

4601008735 нэгж талбарын дугаар бүхий 10 га						
№	Өргөрөг			Уртраг		
1	42	36	56.04	107	29	28.18
2	42	37	2.78	107	29	22.1
3	42	37	9.97	107	29	36.7
4	42	37	3.23	107	29	42.78



Зураг 3. Гаалийн хяналтын талбайн байршлын зураг



Зураг 4. Гаалийн хяналтын талбайн ойролцоох ТХГН байршлын зураг

ХОЁР. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

Нийгэм, эдийн засаг: Өмнөговь аймаг 1931 онд байгуулагдсан ба Монгол Улсдаа газар нутгийн хэмжээгээрээ хамгийн том аймаг юм. Уг аймаг нь Монгол улсын хамгийн өмнөд хэсэгт оршдог бөгөөд урд талаараа БНХАУ-тай, баруун талаараа Баянхонгор, баруун хойд хэсгээр Өвөрхангай, хойд талаараа Дундговь, зүүн талаараа Дорноговь аймгуудтай тус тус хиллэн оршино.

Аймгийн төв Даланзадгад хот нь Улаанбаатар хотоос 560 км зайтай. Монгол улсын хэмжээнд хамгийн том 165,0 мянган кв.км нутаг дэвсгэртэй ба хүн амын суурьшил сийрэг 3,4 квадрат километр нутагт 1 хүн, 13,2 квадрат километр нутагт 1 өрх ноогдон хүн ам суурьшиж байна.

Өмнөговь аймгийн Ханбогд сум нь 1924 онд Галба нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 1931 оноос Ханбогд нэртэйгээр өргөжин хөгжиж байна. Номгон, Хайрхан, Жавхлант, Гавилууд, Баян гэсэн 5 багийн нийт 1450 өрхтэй. Нийт өрхөөс сумын төвийн 1047 өрхөд 2892 иргэн, 403 малчин өрхөд 1408 иргэн бүгд 4300 хүн амьдарч байна.

Хүн ам : Тус сум нь 2020 оны жилийн эцсийн өрх, хүн амын тооллогоор 1988 өрхийн 8718 суурин хүн амтай байгаагийн 33.9 хувь нь 0-18 насны хүүхэд, 31.1 хувь нь 18-35 насны залуучууд, 31.4 хувь нь 36-аас дээш насны хүмүүс, 3.6 хувь нь тэтгэврийн насны ахмадууд эзэлж байгаа ба нийт хүмүүсийн 59.4 хувь нь эрэгтэйчүүд байна.

Сумын нийт хүн амын 6 хувь нь, өрхийн 7 хувь нь Хайрхан багт хамаарна. Сумын хэмжээнд нэг өрхөд ногдох хүний тоо 2018 оны байдлаар 3.6 – 5.0 байгаагаас Хайрхан багт нэг өрх дунджаар 4.0 гишүүнтэй байна.

2019 онд сумын хэмжээнд нийт 223 хүүхэд шинээр мэндэлснээс 129 нь эрэгтэй 94 нь эмэгтэй байв. Мөн онд нас барсан хүний тоо 36 байсан бөгөөд үүнээс 19 нь эрэгтэй 17 нь эмэгтэй байв.

2019 онд шинээр 54 гэр бүл бүртгүүлсэн бол 12 гэр бүл гэрлэлтээ цуцлуулжээ. Өнгөрсөн онд нийт 3 хүүхэд үрчлэгдсэн байна.

Мал аж ахуй: Мал сүргийн бүтэц:Сумын хэмжээнд 200560 толгой малтайгаас 32860 тэмээ, 10390 адуу, 6830 үхэр, 54240 хонь, 96240 ямаа байна.Сумын хэмжээгээр нутгийн шилмэл омог буюу Галбын говийн улаан тэмээ 32860 толгой тоологдсон нь нийт малын 16.4 хувийг эзэлж байна. 385 малчин өрх, 273 мал бүхий өрх байгаа нь сумын нийт өрхийн 45,4 хувийг эзэлж байна

Сургууль: Ерөнхий боловсролын 11 жилийн сургуулийн 29 бүлэгт 820 гаруй хүүхэд өдрөөр суралцаж, бага ангийн хамран сургалт 100 хувь, суурь боловсролын хамран сургалт 100 хувьд хүрсэн. Ерөнхий боловсролын сургуульд мэргэжлийн багшийн хангалт 100 хувь байна. Дотуур байрны 1 барилгатай, 80 хүүхдийн байрны барилгыг зориулалтын дагуу ашиглаж байна. Төрийн өмчийн 125, 175 хүүхдийн багтаамжтай 2 цэцэрлэгт 350 орчим хүүхэд хүмүүжиж хамран сургалт 92 хувьтай байна. Тус 2 цэцэрлэгт нийтдээ 47 ажилтан ажилладаг.

21-р цэцэрлэг Их булаг хороололд байршилтай 125 хүүхдийн хүчин чадалтай, одоогоор 150 хүүхэд хүмүүжиж байна. 18 багш, ажиллагсадтай 1966 онд ашиглалтад орсон. чулуун барилга. 50 хүүхдийн багтаамжтай барилга анх баригдсан, 2004, 2011 онуудад өргөтгөл засвар хийгдэж 125 хүүхдийн багтаамжтай болсон. 175 хүүхдийн цэцэрлэг

Эмнэлэг: Сум дундын эмнэлэг Дөрөлж хороололд байрлалтай. 8 ортой. 3 их эмч, бага эмч, эх баригч бага эмч нийт 28 ажилтан ажилчидтай. Барилга 1978 онд ашиглалтад орсон тоосгон барилга. Нөөц 50 квт дизель цахилгаан үүсгүүртэй. Төвлөрсөн уурын зууханд холбогдсон. 2013 онд 50 ортой эмнэлгийн барилгын ажил эхэлсэн.

Геологийн тогтоц: Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хаданд орчмын газар нь Ханбогд сумын төвөөс зүүн урагш 70 орчим км-т д.т.д 1000-1005м өндөртэй жижиг толгод, жалга судар болон элсэн довтог бүхий газар байрладаг. Энд монгол орны хөрсний ангиллаар тал хөндийн бүлэг хөрсний цөлийн хөрсний хэв шинжид багтах цөлийн сайр чулуурхаг Бор_саарал, цөлийн элсэн хучаастай Бор саарал хөрс болон хужир мараа, хагас бэхэжсэн элс гэсэн цөөн хэдэн төрлийн хөрс тархсан байна. Эдгээр хөрснөөс зонхилон тархсан нь цөлийн элсэн хучаастай Бор саарал болон сайр чулуурхаг Бор саарал хөрснүүд зонхилон тархсан байна.

Геоморфологи, гидрогеологийн нөхцөл: Геоморфологийн мужлалаар Төв Азийн геоморфологийн их мужийн Дундговь-Өмнөговийн мужид хамрах бөгөөд хотгор гүдгэрийн үндсэн шинж гэвэл уудам чулуурхаг хотос хоолой, хужир мараа бүхий тал зонхилох ажээ. Эндэх газрын гадарга бүрэлдэн тогтоход дэлхийн дотоод хүчнээс гадна салхи их үүрэг гүйцэтгэж түүний нөлөөгөөр энд тэнд элсэн хуримтлал үүссэн байдаг. Нөгөө талаар говь цөлийн нөлөөгөөр физик өгөршил, элэгдэл эвдрэл хааяагүй бий болж байжээ. Эндэх газрын гадаргыг ерөнхийд нь тэгшрэлийн гадарга, элэгдэл хуримтлалын гадарга гэж ялгаж үзэж болно. Ханбогд орчимд дорвитой өндөр уул байхгүй. Газрын гадаргын үнэмлэхүй өндөр нь далайн түвшнээс дээш 900-1300 метрийн хооронд хэлбэлзэж хамгийн өндөр нь баруун хойш 60км орчимд Ханбогд уул(1350м), зүүн зүгт 25км-т Агуй уул (1277 м), зүүн хойш 22км-т Хайрхан уул 1161м өндөр, цав толгод нь томоохон боловч нар салхи, хүйтний өгөршлийн улмаас элэгдэл эвдрэлд орж өнчин толгод мэт харагдана.

Төсөл хэрэгжих талбайн орчимд одоогоор Таван Толгой Транс зэрэг ачаа тээврийн компаниуд байрладаг бөгөөд хүнд даацын автомашины хөдөлгөөний улмаас ойр орчны талбай нь техноген элэгдэл, эвдрэлд өртсөн боловч шинээр төлөвлөж байгаа гаалийн хяналтын талбай байгуулах газар нь элэгдэл эвдрэлд одоогоор өртөөгүй байна.

Физик бохирдол: Гаалийн хяналтын бүсэд хүнд даацын машин техникийн хөдөлгөөнөөс дуу чимээ шуугиан ба доргион үүсэж байна.

Шуугиан нь дараах байдлаар хүн ба орчинд нөлөөлнө.

Тархины эд эсүүдийг гэмтээж төв мэдрэлийн системд нөлөөлснөөр түргэн ядрах, анхаарал сулрах, нойргүйдэх, тавгүйтэх байдал үүсгэн хөдөлмөрийн бүтээмжийг бууруулна.

Зүрх судасны үйл ажиллагаанд өөрчлөлт орох улмаар даралт ихэсгэх, бодисын солилцоо, хоодоод гэдэсний хэвийн ажиллагааг алдагдуулж, хоол шингэлтэд сөргөөр нөлөөлдөг байна.

Сонсголд онцгой нөлөөлнө. Ялангуяа өндөр давтамж бүхий үргэлжилсэн шуугиан нь хүний сонсголыг муутгаж аажимдаа сонсголоо бүрмөсөн алдах аюулд хүргэж болзошгүй юм. Шуугиан ихтэй газар хүн түр ажиллаад гарахад тодорхой хугацаанд чих сонсох чадвараа алдаж, дараа нь сэргэдэг. Ийм орчинд хүн удаан хугацаагаар ажиллавал аажимдаа сонсголоо бүрмөсөн алдах аюултай. Мөн даралтат хий үлээх (хий гадагшлах), төмөр нүдэх, давтах, чихний ойролцоо тэсрэлт, дэлбэрэлт болох нь хурц шуугиан гаргах бөгөөд сонсголд онцгой аюултай нөлөө үзүүлнэ.

Шуугиан нь бас далдлах нөлөө үүсгэдэг, өөрөөр хэлбэл шуугианаас болж хүмүүсийн хоорондын хэвийн харьцаа алдагдаж мэдээлэл ба дохио санамж, анхааруулга сонсох зэрэгт саад болдог. Ялангуяа машины чимээ шуугиан нь ажиллагсдын хоорондын хэвийн харьцаа, анхааруулга, дохио санамжийг далдалж анхаарал сулруулснаар аваар, осолд ч хүргэж болзошгүй юм.


Шуугиан нь орчинд тодорхой давтамж бүхий хэлбэлзэх долгионоор тархах бөгөөд өндөр нам нь хэлбэлзлийн давтамж Гц-ээр тодорхойлогдоно. Давтамж нь хэчнээн өндөр байх тутам дуу төдий чинээ өндөр байдаг. Хүний сонсох эрхтэн 16-аас 20000 Гц хүртэлх давтамж бүхий дууг сонсдог байна. 16 Гц-ээс бага давтамж бүхий дууг хэт нам дуу, 20000Гц-ээс их давтамжтай дууг хэт өндөр дуу гэх бөгөөд эдгээр дууг хүн сонсдоггүй.

Шуугиан нь өндөр, нам давтамжийн олон авианы хослол юм. Өөрөөр хэлбэл орчинд тархаж байгаа дуу шуугиан нь дан ганц цэвэр авианаас бүрддэггүй. Нэгэн хэвийн үргэлжилсэн шуугианаас, өөрчлөлт ихтэй шуугиан нь хор нөлөө ихтэй. Мөн өндөр авиа нь нам авианаас, цэвэр авиа нь хосолсон авианаас илүү тээртэй бөгөөд гэмтэл учруулах нь илүүтэй байдаг.

Гадаргын ус: Тухайн бүс нутагт гадаргын усны сүлжээ маш сийрэг бөгөөд үндсэндээ байнгын урсацтай гол горхи байхгүй юм. Энэ шалтгаанаар ажиглалт хэмжилтийн цуваа бүхий гадаргын усны горим, нөөцийн ажиглалт хэмжилтийн цэг харуул энэ бүс нутагт байхгүй болно. Энэ бүс нутагт гол, сайрын урсац нь хаврын шар ус болон зуны хур борооны үерийн уснаас голчлон бүрдэх бөгөөд тэдгээрийн хэмжээ нь уур амьсгал, газрын гадаргуугийн байдал, тэжээгдэл зэргээс шалтгаална. Зуны улиралд богино хугацаанд орсон эрчимтэй аадар борооны улмаас дээр дурдсан уул болон тэдгээрийн салбар уулсаас эх авах гол, сайруудад шар ус, хур борооны үер, уруйн үер үүсдэг. Энэ нь улмаар хөрсийг элэгдүүлэн барилга байгууламж эвдэрч нүрэх зэргээр багагүй хохирол учрахад хүргэж болзошгүй.

Гадаргын урсац нь сав газрын физик газар зүйн болон өндрийн бүс бүслүүрийн онцлогоор илэрхийлсэн ерөнхий зүй тогтолтой байдаг. Иймд сав газрын физик газар зүй, хэвгий зэрэг хүчин зүйлсийн онцлогийг тусгасан урсцын хуваарилалтыг интеграл үзүүлэлт болох урсцын модуль ($m, l/сек км^2$) ба сав газрын дундаж өндрийн (H, m) хамаарлаар илэрхийлэх нь зохимжтой байдаг.

Дээр дурдсан хамаарлаар бол судалгааны талбар нь түр зуурын урсацтай хуурай сайрууд бүхий Төв Азийн гадагш урсацгүй ай савын Говь цөлийн бүс нутагт хамаарна. Энэхүү хамаарлаар судалгааны бүс нутагт гадаргын ус нь 0.02-өөс 0.05 л/сек км² хооронд хэлбэлзэнэ.



Зураг 5. Зуны хур бороо (а) болон хаврын шар усны (б) үерийн хамгийн их урсац, мм

Хүснэгт 4. Хоногт орсон 1 хувийн хангамшил бүхий хур бороо

Д/д	Аймаг	Сум-өртөө	Ажиглалтын хугацаа	Ажигласан жилийн		
				Хамгийн их	Хамгийн бага	Дундаж
1	Өмнөговь	Ханбогд	1978-1990	42.7	7.0	21.1
2		Цогт-Овоо	1963-1990	42.0	7.7	17.0
3		Даланзадгад	1940-1989	138.0	7.4	25.7

Судалгааны бүс нутаг орчмын хуурай сайруудад гадаргын урсац үүссэн ул мөр тодорхой ажиглагдаагүй ба ургамлын гарц муу, гантай байгаа зэрэг нь сүүлийн жилүүдэд тус бүс нутагт хур бороо бага орсон болохыг илтгэж байна. Түүнчлэн, сүүлийн жилүүдэд дэлхий дахинаа ажиглагдах болсон уур амьсгалын дулаарал болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн улмаас говь нутгийн, байнгын үстай байдаг цөөн тооны тойром, баянбүрдийн ус хатаж, ширгэх үйл явц давамгайлж байна.

Говь нутгийн газрын гадаргын өндөршлийн ялгаа төдийлөн их биш ч, өргөн хөндий тал ихтэй, хур борооны, ялангуяа үерийн үед их хэмжээний хохирол, сүйтгэл учруулж чадахуйц (усыг бодвол нягт ихтэй, эвдэх, сүйтгэх хүчин чадал өндөртэй) шавар, чулуун холимог бүхий уруйн үер эдгээр тод бус илрэх судаг, сайраар урсан ирэх магадлал өндөртэй. Ийм байдал, ялангуяа нам уулс, тэдгээрийн ойр орчмын газрууд, тэдгээрээс гарсан ам хөндийн хуурай сайруудад түгээмэл ажиглагдах тул үер усны аюулаас хамгаалах далан хаалт, гүүр, гарцыг зохих стандартын дагуу хийж гүйцэтгэх хэрэгтэй. .

Газрын доорх ус: Судалгааны талбай Төв Азийн гадагшаа урсацгүй ай савд багтана. Ханбогд уулын хавцлуудад байнгын урсацтай, өвөл дошин үүсгэдэг булаг ундарна. Уулын сайруудаар хаврын шар усны болон хур тунадас элбэгтэй үед үерийн ус өнгөрнө. Мөн хур тунадастай дулааны улиралд хоолойнуудын нам дор хэсэгт нуур цөөрөм үүснэ. Энэ газар нутаг нь нэлээд хуурайд тооцогдох бөгөөд агаарын харьцангуй чийгшлийн жилийн дундаж хэмжээ 40% -иас бага байдаг. Агаарын харьцангуй чийгшил 30% -иас бага байх өдрийн тоо өвлийн улиралд 10 орчим, зуны улиралд 10 аас дээш байдаг. Хур тунадас багатай, олон жилийн дунджаар жилд 99мм хур тунадас ордог бөгөөд энэ нь хангай нутгийнхаас 2-3 дахин бага байна. Говь нутагт хэт халсны улмаас агаарын босоо урсгал идэвхтэй хөгжиж эрчимтэй аадар бороо орох тохиолдол гардаг. Энэ бүсэд жилд орох тунадасны ихэнх хувь нь дулааны улирал буюу 5-8 сард, жилд ордог тунадасны 93.9% энэ саруудад ордог. Төслийн талбай нь гидрогеологийн Өмнөд системд багтах ба Монгол улсын 29 сав газрын Алтайн өвөр говийн сав газарт хамаарна. Гидрогеологийн Өмнөд системийн хэмжээнд гадаргын ус түн ховор.

Хөрсөн бүрхэвч: Өмнөговь аймгийн Ханбогд сум нь ерөнхий газрын өндөр далайн төвшнөөс дээш 900–1100 метрийн хооронд хэлбэлзэнэ. Талбай орчим нь Монгол орны хөрс-газарзүйн

мужлалаар Говийн их мужийн өргөргийн бүсшилийн цөлийн бор саарал хөрсний 14-р тойрогт хамрагдана. Энэхүү тойрогт нам уулс, толгодын хэсгээр эх чулуулгийн илэрцтэй, дутуу хөгжилтэй сайр чулуурхаг цөлийн бор саарал /гөлтгөнөгүй/, тал хөндий, нам хотос хэсгээр цөлийн бор саарал, цөлийн мараалаг бор саарал, уугуул хэлбэрийн мараа хөрс, элсэн хөрс голлон тархана [Монгол улсын үндэсний атлас, 2009].

Талбайн орчмын нутагт тархсан хөрсийг ялгаж тогтооход Цөлийн бор тархсан байна.

Гаалийн хяналтын талбайд явагдах үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвчид эвдрэл, бохирдлын дараах түгээмэл хэлбэр, өөрчлөлтүүд үүснэ. Үүнд:

- Гаалийн хяналтын талбай орчим нь сийрэг, нимгэн, элсэнцэр хөрстэй, энэ нь ус нэвтрүүлэх чадвар өндөртэй учир хөрсөнд ямар нэг уусамтгай болон шингэн хаягдал алдагдсан тохиолдолд хурдан нэвчиж тархах аюултай.
- Авто машин, хүнд техникийн нөлөөгөөр хөрсний гадаргын ургамал бүрхэц сийрэгжих, хөрс эвдрэх, нягтарч хатуурах, бүтэц алдагдах
- Улмаар хөрсний хими, физик, геохими, биохимийн хөдлөл зүйн горим өөрчлөгдөх
- Талбайд явагдах ажлын явцад ашиглагдах хайрга чулуулаг болон барилгын материалын хог хаягдлаар эрүүл хөрс дарагдаж дагтарших
- Механик үйлчлэлээр (машин дугуй, хүний хөл) талхлагдаж сийрэгжих, нимгэрэх
- Хог ургамалд баригдах, доройтох
- Ухсан газарт ландшафтын эвдрэл үүсэж, хөрсний генетик үе давхаргууд холилдон морфологи тогтоц бүрмөсөн алдагдах
- Газрын гүн дэх хурдас чулуулаг ил гарч, хөрсний масс холилдох
- Хөрс салхинд хийсэж элэгдэж эвдрэх үйл явц нь ихсэн тоосжилт нэмэгдэх зэрэг болно.

Төслийн үйл ажиллагаа явуулахдаа хөрстэй шууд байдлаар харьцахгүй боловч нүүрс ачиж тээвэрлэх автомашинууд хөрсийг элээх, эвдэх байдлаар нөлөөлөх байдалтай юм.

Мөн тээвэрлэлт хийх үед боссон тоос шороо нь ойр орчны эрүүл хөрсөнд бууснаар ургамлан бүрхэвч болоод хөрсний чанарт сөргөөр нөлөөлөх болно. Талбайгаас ачилтад ашиглагдах автомашин, тээврийн хэрэгслүүд замгүй газраар явж хөрсөн бүрхэвчийг гэмтээж болзошгүй юм.

Гаалийн хяналтын талбай нь үйл ажиллагааныхаа явцад хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Үүнд:

- Ашиглалтын үеийн тоосжилтыг дарах бууруулах үүднээс байгаль хамгаалах төлөвлөгөөнд заагдсан хугацаа, давтамжаар орчны агаар, хөрсийг чийгшүүлж байх
- Талбайд ашиглагдах автомашинуудын явах замыг тодорхой болгон замыг тэмдэгжүүлэх
- Жолооч нарыг хөрсөн дээр тос, масло асгахгүй байхыг урьдчилан анхааруулах, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах
- Автомашины засвар үйлчилгээний талбайг засаж, цементлэх
- Гаалийн хяналтын талбайн хэмжээнд ухагдах бүх нүх суваг, цооног, босоо ам зэргийг ухагдах гадаргын өнгөн хөрсийг стандартын дагуу 20 см зузаантай хуулан авч, тусгай газарт овоолон байршуулах, хөрсний үржил шим алдагдахаас хамгаалах
- Техникийн нөхөн сэргээлтээр газрын гадаргуугийн өнгөн хэсгийг аль болох анхдагч төрх байдалд нь ойртуулан засаж тэгшлэх, хэлбэршүүлэх
- Машины олон салаа зам гаргахаас сэргийлэх, гол замыг засаж тохижуулах

- Талбайн барилгын ажил дууссаны дараа ашиглагдсан талбайн гадаргын эвдэрсэн хэсгийг хэлбэршүүлэх, тэгшлэх, шимт хөрсөөр хучих зэргээр техникийн нөхөн сэргээлт хийх
- Техникийн нөхөн сэргээлт хийсэн газрыг өтөг бууцаар бордож, олон наст ургамлын үр цацах, мод бут суулгах, нутгийн унаган ургамал тарих зэргээр биологийн нөхөн сэргээлт хийх
- Талбайн барилгын ажилд хэрэглэгдэх бодис, материал, тоног төхөөрөмжийг зориулалтын агуулах саванд хадгалж, хөрс рүү алдагдахаас сэргийлэх.

Автомашин зогсоолын талбайг тэгшлэн шатах, тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж цардах, тэмдэгжүүлэх.

Ургамлан бүрхэвч: Гаалийн хяналтын бүс нь Монгол орны ургамал газарзүйн мужлалаар Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарна (Н. Өлзийхутаг. 1989). Нам уул нуруу, говь цөл, цав толгодын тэдгээрийн хоорондын цөлийн хээрийн ургамалжилтай бөгөөд сөөгнөөс харгана, заримдаг сөөгөнцөрүүд дэд зонхилно (И.Түвшинтогтох, 2014.).

Цөлийн хээрийн тархац Өдлөг хялганууд (*Stipa gobica*, *S.glareosa*, *S.brevifolia*), зонхилон тархаж буй газар нутгаар тодорхойлогдоно. А.А.Юнатов (1974) цөлийн хээрт Өдлөг хялгана, Зүүнгарын хазаар өвс (*Cleistogenes soongorica*), Таанаас (*Allium polyrhizum*) гадна заримдаг сөөгөнцөр, сөөг зонхилсон бүлгэмдлүүдийг хамааруулан үзсэн байдаг. Түүнчлэн цөлийн хээрийн бүсэд хонхор хотос, шал тойром зэрэг хөрсний үс ойр газраар бүсийн бус ургамалжил болох цайдамын ургамалжил (*Stipa splendens*, *Reaumuria soongorica*) зонхилно. Цөлөрхөг хээрийн ноёлогчид нь 3 зүйл Хялгана (*Stipa gobica*, *S.glareosa*, *S.brevifolia*), 1 зүйл Хазаар өвс (*Cleistogenes soongorica*), Таана (*Allium polyrhizum*), сөөгнөөс 4 зүйл Харгана (*Caragana pygmaea*, *C.leucophloea*, *C.bungei*, *C.korshinskyi*), Орог тэсэг (*Krascheninnikovia ceratoides*) болон заримдаг сөөгөнцөр шарилжууд (*Artemisia rutifolia*, *A.xanthochloa*, *A.santolinifolia*, *A.pychnoriza*) болно. Бусад заримдаг сөөгөнцөрүүд (*Artemisia frigida*, *A.caespitosa*, *A.xerophytica*, *Anabasis brevifolia*, *Salsola passerina*, *Convolvulus gortschakovii*, *Ajania achilloides*, *A.trifida*, *Reaumuria soongorica*, *Asterthamnus heteropappoides*) дэд зонхилно. Дагуул зүйл ургамлууд нь заримдаг сөөгөнцрөөс *Oxytropis aciphylla*, *Ptilotrichum canescens*, *Kochia prostrata*, алаг өвснөөс *Allium mongolicum*, *Gypsophilla desertorum*, *Convolvulus ammanii*, *Lagochilus ilicifolius*, *Scorzonera divaricata*, *Aster hispidus*, *Asparagus gobicus* зэрэг бол, цөөн настаас *Salsola pestifera*, *S.collina*, *Artemisia scoparia*, *Neopalassia pectinata* зэрэг ургамлууд болно (Түвшинтогтох, 2014).

Гаалийн хяналтын талбай орчмын ургамлан нөмрөг хүн, малын талхагдалд бага өртсөн боловч машин техникийн нөлөөлөл нэмэгдэхэд хүчтэй талхагдал доройтолд орох боломжтой. Ойр орчимд малчин айл өрх цөөхөн, бэлчээрт ашиглагдаж байгаа газар бага байна. Харин авто машины зам дагуух газар нэлээд хэмжээгээр эвдрэл талхагдалд орсон байна. Мөн цаашид гаалийн хяналтын талбай орчмын барилгын ажлын явцад ургамлан нөмрөг талхлагдаж доройтох эрсдэл ихтэй. Мөн хүчтэй салхины нөлөөгөөр зарим газрын ургамлан нөмрөг нь хагд хүримтлал үүсэх боломжгүй болж улмаар доройтолд орсон байна.

Гаалийн хяналтын талбайн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөгт талхагдал, доройтлын дараах түгээмэл хэлбэр, өөрчлөлтүүд үүснэ. Үүнд:

- Цагаанхадад байрлах гаалийн хяналтын талбай орчмын ургамлан нөмрөгийн биомассын нөөц хомсдох, талхлагдах
- Авто зам орчмын ургамал бүрхэц сийрэгжсэнээр хөрс эвдрэх үйл явц түргэсэх

- Ургамлан нөмрөгийн бүлгэмдэл болон зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт гарч, зүйлийн тоо багасах
- Талбайг барьж байгуулах явцад ашиглагдах хурдас чулуулаг, барилгын материал, техник тоног төхөөрөмжийн хог хаягдлаар эрүүл ургамлан нөмрөгтэй газар дарагдах
- Механик үйлчлэлээр (машины дугуй, хүний хөл) талхлагдаж сийрэгжих, ургамлын нийт бүрхэц багасах

Эвдэрч доройтсон ургамлан нөмрөгт хог ургамлын зүйлийн тоо нэмэгдэх.

Тусгай хамгаалалттай газар нутаг: Төсөл хэрэгжих Цагаанхад орчмын нутаг дэвсгэр нь түүх, соёлын дурсгалт зүйлс болон тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэс, хамгаалалтын бүсэд ордоггүй. Энэ орчимд тусгай хамгаалалтад авахаар төлөвлөж буй объект болон түүх, соёлын дурсгалт зүйлс байхгүй болно.

Түүх соёл, археологийн дурсгалт зүйлс: Түүхийн дурсгалт Археологийн олдворыг харьяа байгууллагын захиргаанд тайлагнаж байхыг соёлын өв үнэт зүйлсийг хамгаалах хуульд заасан байдаг. Тэдгээр түүх, шинжлэх ухаан, соёлын үнэт зүйл болох газар, хөрс нь улсын хамгаалалтад байх бөгөөд археологийн аль ч олдвор улсын өмч болдог. Археологийн ба соёлын өв үнэт дурсгалт зүйлс нь байгальдаа нөөцлөгдөн хадгалагдах зарчимтай гэж хуульд заасан байдаг. Дурсгалт газар, үнэт зүйлс нь эрсдэлд орохоор байвал эрх бүхий шинжилгээний байгууллага тэдгээрийг бүртгэн авч нүүлгэн шилжүүлж болно.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслөөс үүсэх гол нөлөөллүүд

Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт. Байгалийн төрөл зүйлүүдээс зэрлэг ан амьтдын орон зайн өөрчлөлтөд нөлөөлөх нөлөөллийн зэрэг нь “бага”, харин агаар орчны бохирдол, газар доорх усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл бараг дундаас бага зэрэгтэй байсан бол геологийн тогтцын өөрчлөлтөд хөрсний элэгдэл, эвдрэл ба бохирдол, ургамлын төрөл зүйлийн өөрчлөлт зэрэг нөлөөлөл дунд зэрэг байхаар гарсан байна.

Байгаль орчны чанар, нийгмийн өөрчлөлт. Нүүрс тээвэрлэх үйл ажиллагааны үед гарах тоос, тоосонцроос бохирдох бохирдол их, хөрсний бохирдол, агаар орчны дуу чимээний физик бохирдол, ундны усны чанар хэмжээнд “дунд” зэргээр нөлөөтэй үнэлэгдэж байна.

Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, соёлт давхаргад үзүүлэх нөлөөлөл. Байгалийн үзэсгэлэнт төрх, орчны ландшафтын хэлбэр өнгө төрх, тусгай хамгаалалтай газарт үзүүлэх нөлөөлөл байхгүй. Түүх соёлын дурсгалт зүйл, археологийн олдворт үзүүлэх нөлөөлөл байхгүй байна.

Бусад нөлөөлөл. Автозамын тээвэрлэлтээс шалтгаалан хөрс эвдрэх, ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих болон байгалийн давагдашгүй хүчин зүйл /хүчтэй салхи, түймэр газар хөдлөл, аянга/-ийн нөлөөллийн зэрэг “бага” байхаар байна.

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Үндсэн зорилго, зорилт

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-н дэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсэж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой. Тиймээс төслийн бүтээн байгуулалт болон үйл ажиллагааны явцад үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзээд холбогдох зардлыг төлөвлөнө. Энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

БОМТ-г хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэгч дараах бодлогыг баримтална. Үүнд:

- БОМТ нь төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдсан байх;
- БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
- БОМТ-г хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад тэсвэртэй болох зэрэг болно.

Хамрах хүрээ

БОМТ нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт хэрэгжих “Гаалийн хяналтын талбайн” үйл ажиллагааны хүрээнд дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалтын хүрээнд хэрэгжих бөгөөд БОННУ-ний тайлангийн 1 дүгээр бүлэгт төслийн хамрах хүрээг тодорхойлсон нь байна. Уг төслийн үйл ажиллагааны явцад хүрээлэн буй орчныг хамгаалах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилт бүхий төлөвлөгөөнд БОННУ-ний тайланд тусгасан зөвлөмжүүдийн хүрээн дэх бүхийл асуудлыг хамрахад БОМТ нь дараах 2 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Төслийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэх арга замууд, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа болон шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ),
- Төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдал, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа орчны болон ажлын байрны нөхцөлийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тусгасан орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ).

Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд баримтлах эрх зүйн баримт бичиг болон шаардлагыг нь зайлшгүй хангаж мөрдөх стандартуудыг БОМТ-нд тодорхой тусгаж өгнө.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Агаарын чанар									
1.	Эрүүл ахуйн шаардлага хангах, үнэрийн бохирдол тархахаас сэргийлэх	Хогийн цэгийн ойр орчмыг дулааны улиралд ялаа, шавж, бактери үржих, үнэрийн бохирдол тархахаас урьдчилан сэргийлж ариутгал хийж байх,	Хогийн цэг	-	10,000	4	40.0	2023 онд	Байгаль хамгаалах тухай хууль Агаарын тухай хууль, MNS ISO 14064.1.2015 Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр (УИХ-ын тогтоол 2011.01.06) MNS 5013:2009 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 4585:2016 Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага
2.	Агаарт хаягдах тоосны хэмжээг багасгах	Салхи шуургатай үед тоос шороо зөвшөөрөгдөх хэмжээнээс их байгаа зам, талбайг усалж байх шаардлагатай.	Төслийн талбай орчимд	-	Үйл ажиллагааны зардлаар		Төсөл хэрэгжих хугацаанд	2023 онд	
3.		Хурдны хязгаар тогтоож 30км/цагаас хэтрэхгүй байх хурдын хязгаарлалтыг заасан тэмдэг тэмдэглэгээ байрлуулах	-	ш	500.0				
4.	Хүнд даацын машин механизмаас ялгарах хий агаарт бохирдол үүсгэх	Гэмтэлтэй тээврийн хэрэгслийг тогтмол засварлах, Монгол улсад мөрдөгдөж буй стандартуудын дагуу хяналт хийх	Засвар үйлчилгээг тогтмол хийх, гэмтэл гарсан тухай бүрд яаралтай арга хэмжээ авах		Дотоод төлөвлөлтөөр		2023 онд		

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2. Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									
1	Хүний үйл ажиллагаагаар бий болгосон зохиомол ландшафт гадаргыг бий болгоно.	- Газрыг үр өгөөжтэй зүй зохистой ашиглах - Төлөвлөгдсөнөөс өөр талбайд нүүрсний овоолго үүсгэхгүй байх, талбайг зохион байгуулалттай ашиглах - Машин, техник болон бусад тээврийн хэрэгслийг тогтоосон маршрутаар явуулах,	Нийт талбай		Төслийн төлөвлөлт, дотоод зардлаар гүйцэтгэх боломжтой			2023 он	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5850:2019 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ” MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх UCS 1701A:2022 “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” хотын стандарт
2.	Хөрс, газрын гадарга хаягдлаар бохирдох	Хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, салхиар тархах, хүр тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн хийцлэлтэй зориулалтын цэг байгуулах	Хог хаягдлын цэг	ш		1,000.0		2023 онд	
		Технологийн горимыг мөрдөж ажиллах, асгаралт үүссэн тохиолдолд саармагжуулах арга хэмжээ авах, шаардлагатай багаж хэрэгслийг төслийн талбайд байршуулах, хэрхэн ашиглах сургалт зохион байгуулах	Нийт талбай	удаа		500.0		2023 онд	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
3. Ургамал, нөхөн сэргээлт, орчны тохижилт									
1.	Төслийн үйл ажиллагаанаас ургамлан нөмрөг устах, нөлөөлөлд өртөх талбайн ургамлан нөмрөг доройтох	Ногоон байгууламж бий болгох, тордож байх	Төслийн талбай орчмын ургамлан нөмрөг					2023	
2.	Тоос, дуу шуугиан зэрэг техноген нөлөөлөл нь ургамлан нөмрөг тоос шороонд дарагдах, стрессдэх зэргээр байгалийн аясаар нөхөн сэргэх, ургах үйл явцад сөрөг нөлөө үзүүлнэ.	Агаарын бохирдлоос сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Төслийн талбай	Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний зардалд тусгасан.				2023	MNS 5914 : 2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS 5918 : 2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага
		Орчныг тохижуулах, мод тарих						2023	
4. Усан орчин									
1.	Усан орчны бохирдол	Газрын доорх усны чанарыг тогтмол хянах	Ус хангамжийн эх үүсвэр		ОХШХ-т тусгасан			2023	
5. Амьтан									
1.	Хууль бус ан агнах	Ажилчдад болон тээвэрлэлтэд оролцох ажилчдад хамгааллын статус бүхий ховор амьтдын ач холбогдол, ан агнуур, худалдааг хориглох, хурдны хязгаарыг байнга барих, зам тээврийн үед амьтан алахгүй байх, амьтны нүүдлийн төлөв болон	Орон нутаг		Үйл ажиллагааны дотоод зардлаар			2023	Амьтны тухай хууль Үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан хөнөөгдөхөөс сэргийлэх 6.1.7. Байгаль хамгаалах тухай хууль

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		үржлийн хэв маягт саад учруулахгүй байх талаар сургалт явуулах.							
2.	Хур тунадас багатай жил зэрлэг амьтад идэш тэжээлээр гачигдах	Шаардлагатай өвс, үндны усаар хангах биотехникийн нэмэлт арга хэмжээг тухай бүрд төлөвлөж хэрэгжүүлэх	Амьтад	боодол	12,000	30	360.0	2023 он	
3.	Үйл ажиллагаанаас амьтдын амьдрах орчин алдагдах, дуу чимээгээр амьтад дайжих	Дуу чимээний эх үүсвэрт хэмжилт хийж, бууруулах арга хэмжээ төлөвлөн ажиллах	Гаалийн хяналтын талбайн дуу чимээний эх үүсвэрүүд дээр	удаа	Дотоод төлөвлөлтөөр			2023 он	
4.	Хог хаягдлыг эмх замбараагүй хаях, түүгээр амьтад хооллох, өвчлөх	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, стандартуудыг мөрдөж ажиллах	Төслийн талбай	-	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан			2023 он	
Сөрөг нөлөөг бууруулах нийт зардал, мян.төг					2,400.0 мян.төг				

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Иймд эзэмшил газрын 10-аас багагүй хувийг тохижилт, агаарын бохирдлыг бууруулах, ургамалжуулах зэрэг зорилгоор моджуулах арга хэмжээг зайлшгүй хийх шаардлагатай юм.

Газрын нөхөн сэргээлт гэдэг нь “эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг нь сэргээх, тэрчлэн хүрээлэн буй орчны нөхцөлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ” юм. Жил бүр мод тарих ажлыг зохион байгуулж, өмнө тарьсныгаа арчлах, амьдраагүй хэсэгт нөхөн тарилт хийх зэргээр уламжлалт тогтсон өдөртэй болсон байх.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Ханбогд сумын ЗДТГ-аас заасан газарт мод тарихаар төлөвлөсөн ба одоогоор байршлын мэдээлэл тодорхой болоогүй байна.

Өмнөговь аймгийн БОАЖГ-ын байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Б. Оргилмаа болон Ханбогд сумын байгаль орчны мэргэжилтэн н.Насандэмбэрэл нараас авсан чиглэлийн дагуу Цагаан хаданд үйл ажиллагаа явуулж буй “Гаалийн хяналтын талбай” төслүүд нь Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000 мод тарихаар тусган ажиллана.

Хүснэгт 6. Ногоон байгууламжийн төлөвлөгөө

№	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал ¹ , төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих	Жигд /3 нас/ Сухай /Знас/ Хайлаас /Знас/ тарьц авах	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын ЗДТГ-аас заасан газарт	Ширхэг	1000	11,250	11,250.0	2023 онд	- Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4
2	Мод бутны арчлалт хамгаалалт	Ургаагүй мод бутыг нөхөн тарих арчлалт хамгаалалт хийх	Төслийн талбай	удаа	1000	-	-	-	- Тэрбум мод үндэсний хөдөлгөөн
3	Төслийн талбайг тохижилтын дагуу мод бут тарьж хашаалах	Жигд /3 нас/ Сухай /Знас/ Хайлаас /Знас/ тарьц авах	Төслийн талбай	Ширхэг	100	11,250	1,250.0	2023 онд	-
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн нийт зардал, мян.төг				12,500.0					

¹ <http://ecoline.tcgroup.mn/index.php/en/2013-04-30-23-44-01>

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжих орчинд сум суурин газар олон жил үйл ажиллагаа явуулсан, тэмдэглэгдэж бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалт зүйл сумын төвийн тухайн орчинд байхгүй.

Төслийн үйл ажиллагааны явцад талбайн хөрсөнд өмнө нь судалгаагаар илэрч байгаагүй олдвор илэрч болдог. Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь төслийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны яамны түсгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Гал түймэр	1. Ажлын талбайд гал түймрээс сэргийлэх боломжтой бүх арга хэмжээг авах 2. Дараах эрсдэл бууруулах арга хэмжээг авах: -Нийт ажилчдыг гал унтраах сургалтад хамруулах, - аюулын гарцын (хэрэв тодорхой биш бол, жишээ нь ганц хаалгатай бол) байрлалыг заасан самбар байрлуулах; галын дохиолол, гал унтраагуур тэмдэг тавьсан байх хэрэгтэй. 3.Гал гарсан тохиолдолд: -Галаас яаралтай гарах -Гал түймрийн үед барилга байгууламж бүрд тохирох зааврыг ашиглах	Төслийн бүх байршилд	-	-	-	2023 он	Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг Гамшгаас хамгаалах тухай хууль, 5 дугаар бүлэг
Хүний эрүүл мэнд муудах	Хүний эрүүл мэнд муудахад харьяа сумын эрүүл мэндийн нэгдсэн төвд хүргэх арга хэмжээг авна.	Төслийн бүх байршилд	-	-	-		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг
Цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол	Урьдчилан сэргийлэх мэдээ болон дохиолол холбооны найдвартай байдлуудыг байнга хангах	Төслийн бүх байршилд	-	-	-		
Автомашин осол	Замын хөдөлгөөний аюулгүйн дүрмийг мөрдөөгүй тохиолдолд авах арга хэмжээний тухай бодлогыг боловсруулж, мөрдөж ажиллах, нэг буюу түүнээс олон автомашин хамарсан осол гарсан тохиолдолд компанийн даатгалын журмыг мөрдөнө. Ослын улмаас хүн бэртэж гэмтэх буюу нас барсан тохиолдолд урьд нь тогтоосон эмнэлгийн түргэн тусламжийн журмыг мөрдөнө. Гал түймэр гарвал галын журмыг мөрдөнө.	Төслийн тээвэрлэлт	-	-	-		Гамшгаас хамгаалах тухай хууль, 5 дугаар бүлэг Аюулгүй ажиллагааны журам, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 5 дугаар бүлэг, Замын хөдөлгөөний дүрэм, Замын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслөөс гарах хог хаягдлын төрлүүд ба хэмжээ: Төслийн хүрээнд дараах хог хаягдалд энгийн болон аюултай хог хаягдлын төрлүүд гарахаар байна. Хог хаягдлын гарцын хэмжээг төсөл хэрэгжүүлэгч хог хаягдлын нэр төрөл бүрээр нь холбогдох эх үүсвэр дээр нь ажлын зураг авалт хийж норматив тогтоох шаардлага тавигдаж байгаа. Бид БОМТ-ний хүрээнд төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ажиллах хүч, ажлын хоног, хэрэглээний норм, техникийн ээлж гэх зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн дараах байдлаар тооцлоо.

Хүснэгт 7. Төслийн үйл ажиллагааны явцад гарах хог хаягдлын хэмжээ

Хог хаягдлын ангилал	Хог хаягдлын нэр төрөл	Хог хаягдлын хэмжээ
Энгийн хог хаягдал		
Дахин боломжтой ашиглах	Цаас	4 ажилтан сард 0.4кг/хүн бичиг цаасны хаягдал
	Шил	Хүнсний баглаа боодлоос 30 хүн/хон*0.6 = 18 кг
	Хуванцар,	Хүнсний болон ахуйн хэрэглээнээс 30 хүн/хон*0.5= 15 кг
	Резин	Техникийн ээлжийн тоогоор тооцно.
	металл, төмөр	Нийт үүсэх хэмжээнээс: <ul style="list-style-type: none"> Ундааны сав баглаанаас 30 хүн/хон* 0.3= 9 кг Техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнээс гарах металлыг тооцоолох боломжгүй байна
Хүнсний хог хаягдал	(гал тогооны хаягдал)	30хүн*0.1кг*30хоног*12сар = 1080кг
Бусад хаягдал	Хэтэрхий бохирдсон ашиглах боломжгүй хог хаягдал	Нийт ажиллагсдын хэрэглээнээс 30 хүн*0.15кг*30хоног*12сар тооцоход 1620 кг
	Ахуйн хэрэглээнээс гарсан дахин ашиглахгүй шингэн хаягдал	Төслийн хүрээнд унд ахуйд ашиглах усны 90 хувь нь ахуйн бохир болж хаягдана.
Аюултай хог хаягдал		
Батарей аккумулятор	Хар тугалгатай батарей	Техникийн ээлжийн тоогоор гарна.
Хаягдал тос ба шингэн түлш	Түлшний тос, дизель	Техникийн ээлжийн тоогоор гарна.
Шингэн хадгалах танк, зөөврийн танк, торхны цэвэрлэгээний хаягдал	Тос агуулсан хаягдал	Тос агуулсан хаягдал нь: <ul style="list-style-type: none"> Тос агуулсан арчих материалын хаягдал Тос агуулсан хөрсний хуулдас
	Хаягдал шингэн катализатор	Тооцох боломжгүй. Катализатор үүсэх нөхцөл үгүй гэж үзнэ. Аккумуляторыг холбогдох үйлчилгээ үзүүлдэг газарт цэнэглэнэ.
Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны тосны хаягдал	Хүнд машин механизмын цэвэрлэгээний хаягдал	Тооцох боломжгүй.

Хог хаягдлын ангилал. Төслийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг дээр заасан байдлаар ангилах бөгөөд тэдгээрт нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлж төслийн талбайн орчинд хог хаягдлыг ангилах, ангилсан хог хаягдлыг төвөг багатайгаар цуглуулах тухай мэдээллийг үйлчлүүлэгч олон нийтэд мэдээлж сурталчлахын зэрэгцээ хогийн цэгүүдийг оновчтой байршуулж холбогдох тэмдэг, тэмдэглэгээг ойлгомжтойгоор хийнэ.

Хүснэгт 8. Хог хаягдлыг зайлуулах

Хог хаягдлын нэр төрөл	Хог хаягдлын хэмжээ
Энгийн хог хаягдал	
цаас	Дахин боловсруулах боломжтой тул эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөхийн тулд гэрээ хийнэ. Түр хадгалалтын цэгийг хуримтлагдах хэмжээ, тээвэрлэлтийн хугацаатайгаа уялдуулан төлөвлөсөн байна.
шил	
хуванцар,	
резин,	
металл, төмөр	
Хүнсний хаягдал, (гал тогооны хаягдал)	Маш бага хэмжээтэй гарах бөгөөд хэт бохирдолтой, удаан хугацаагаар хадгалах боломжгүй хаягдал тул хамгийн цөөндөө 7 хоногт 2 удаа зайлуулна.
Хэтэрхий бохирдсон ашиглах боломжгүй хог хаягдал	Тиймээс эрх бүхий этгээдээр тогтоосон хугацаанд тээвэрлүүлэн зөвшөөрөгдсөн цэгт хүргүүлнэ.
ахуйн хэрэглээнээс гарсан шингэн хаягдал	Бохирын цооногт хуримтлуулан эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулан зайлуулна.
Аюултай хог хаягдал	
Хар тугалгатай батарей	Аюултай хог хаягдлын зөвлөмжийг баримтална. Эрх бүхий этгээдэд нийлүүлнэ.
Ашигласан тос, масло	Аюултай хог хаягдлын хадгалалтын нөхцөл шаардлага хангасан цэгт хадгалж байгаад эрх бүхий этгээдэд нийлүүлнэ.
Хаягдал шингэн катализатор	Катализатор үүсэх нөхцөл үгүй гэж үзнэ. Аккумуляторыг холбогдох үйлчилгээ үзүүлдэг газарт цэнэглүүлнэ.
Машин механизмын цэвэрлэгээний хаягдал	Тооцох боломжгүй.

Хог хаягдал цуглуулах саванд тавигдах ерөнхий шаардлага

5.1 Энгийн болон дахин боловсруулах хог хаягдлыг цуглуулах зөөврийн сав нь дараах ерөнхий шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- 5.1.1. Хогийн сав нь бат бөх, галд тэсвэртэй материалаар хийгдсэн, зэврэлтээс хамгаалагдсан байх
- 5.1.2. Хогийн савны хог цуглуулах хэсгүүд нь дахивар хог хаях зориулалтыг заасан стандарт мэдээлэх тэмдэг, өнгөтэй байх
- 5.1.3. Хогийн сав нь хог хаягдлыг ангилах, цуглуулах, ачих, тээвэрлэх технологид нийцсэн байх
- 5.1.4. Хог хаягдал салхиар тархах, хур тунадасны ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас сэргийлсэн таг эсхүл саравчтай байх
- 5.1.5. Түгээмэл хэрэглэгддэг угаалга цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бодист тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар материалаар хийгдсэн байх
- 5.1.6. хогийн савны металл хийцийн эд ангийг зэврэлтээс хамгаалж энэхүү стандартад заасан өнгөөр, стандарт шаардлага хангасан будгаар технологийн дагуу будсан байх
- 5.1.7 энгийн болон дахин боловсруулах хог хаягдлын савыг техникийн хяналтын төвүүдэд (бойлерын өрөө эсхүл агааржуулалтын систем) байрлуулж болохгүй. Аливаа хий, ус эсхүл гүйдлийн тоолуур эсхүл бусад мэдрэмтгий хэрэгслийн гэмтлээс бүрэн хамгаалсан байх
- 5.1.8. органик хог хаягдлын хувьд хангалттай агааржуулалтыг хийж байх шаардлагатай, агааржуулалт нь цахилгаан эсхүл байгалийн хэлбэрээр байж болно. Агаар солилцооны харьцаа нь хамгийн багадаа 0.8 м³/ц байна.

- 5.1.9. Хогийн сав нь нарны шууд тусгал тусахаас сэргийлсэн саравч эсхүл сүүдэр газар байршсан байна.

5.2. Энгийн хог хаягдал болох ахуйн хог хаягдал, органик хог хаягдал, цаас, шил, хуванцар, лааз зэрэг дахивар хог хаягдлыг тухайн төрлийн заасан савнуудад цуглуулж тодорхой хугацаанд хадгална.

5.3. Органик хог хаягдал нь гадаргууг хуурах, зэв үүсэх нөхцөл бүрдүүлдэг тул цайраар бүрсэн ган болон төмөр саванд хадгалж болохгүй. Цуглуулах савны дүүргэлт доорх байдлаар байвал тохиромжтой. Үүнд

5.3.1. Хог хаягдлын нягтаршлын дээд хязгаар $0,4\text{кг}/\text{дм}^3$ х нэрлэсэн хэмжээ (жишээ нь: 240 литр х 96кг)

5.3.2. Хог хаягдлын нягтаршлын дээд хязгаар $0,4\text{кг}/\text{дм}^3$ х нэрлэсэн хэмжээ, 1750 кг хүртэл

5.3.3. Хог хаягдлын нягтаршлын дээд хязгаар $0,4\text{кг}/\text{дм}^3$ х нэрлэсэн хэмжээ, 2500 кг хүртэл



Зураг 6. Хог олон төрлөөр ангилан түр хадгалах сав/жишээ/²

Хүснэгт 9. Аж ахуй нэгж байгууллага байршуулах хогны савны шийдэл

Хэмжээ	Шийдэл	
Урт-3м Өндөр 1.5м Өргөн 1.5м	<ul style="list-style-type: none"> • Хүний биеийн өндөрт тохирсон • Савны амсрыг зөвхөн дахивар хийхээр тооцож хийсэн • Ангилсан хаягдлыг ачихад хялбараар шийдэж дахивар бүрээр салж ачилт хийгдэнэ. • Хаягжилтыг цоолтуураар шийдсэн • Шил ангилах хэсэг нь унаж хагарахаас сэргийлсэн, том жижиг хэмжээтэй 	<ul style="list-style-type: none"> • Ус орохоос хамгаалж газраас хөндий • Хоёр талаасаа дахивраа хийх шийдэлтэй п • Нараар цэнэглэгдэж хүн ойртохоор мэдэрч асдаг гэрэлтэй • Савнуудыг холбосон салахгүй байх оньсон түгжээтэй • Ангилан ялгах өнгийг шийдсэн.

² [Хотын стандарт | Хотын стандарт, хяналтын газар \(ub.gov.mn\)](http://ub.gov.mn)



Зураг 7. Нүхэн жорлон ариутгах ³

Халдваргүйжүүлэлтэнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан хлорлог бодисыг хэрэглэнэ.

Хлорлог бодисыг ашиглан халдваргүйжүүлэх уусмал бэлтгэх:

Халдваргүйжүүлэх уусмал бэлтгэхийн өмнө хлорын идэвхийг тодорхойлно. Иргэд өөрсдөө халдваргүйтгэл хийх бодисоо худалдан авахдаа идэвхтэй хлорын хэмжээг тодорхойлсон шинжилгээний дүнг мэдэж авах нь чухал.

Дараах томъёог ашиглан уусмал бэлтгэхэд шаардлагатай бодисын хэмжээг тооцон гаргана

Бэлтгэх уусмалын% / хлорын идэвх% x 1000 = 1 л ус тутамд хийх бодисын хэмжээ /гр/

Жишээ: 40%-ийн идэвхтэй кальцийн гипохлорит 0.5%-ийн 1 л уусмал бэлтгэхэд хэчнээн хэмжээний бодис авахыг тооцож үзье.

$t = 0.5\% / 40\% \times 1000 = 12.5$ грамм

12.5 грамм бодис жинлэн авч 1 литр усанд уусган хэрэглэнэ.

АНХААР: Халдваргүйжүүлэх уусмал бэлтгэх усны температур 30-40 градус байх нь тохиромжтой.

Хуурай бодисоос халдваргүйжүүлэх уусмал бэлтгэсэн тохиолдолд уусаагүй хэсгийг тунгаах зорилгоор 30 минут байлгаж хэрэглэнэ

Хэрэглэх арга: Халдваргүйжүүлэлтийн уусмалыг 1 м³ талбайд 2 литр уусмал орохоор тооцож, нүхэн жорлон, бохирын цооногийн эзлэхүүнд тохируулан уусмалаа бэлтгэнэ.

³ [Нүхэн жорлонд халдваргүйжүүлэлт хийх зөвлөмж \(inspection.gov.mn\)](http://inspection.gov.mn)

Халдваргүйжүүлэлт хийсний дараа 1-2 цаг нүхэн жорлонгийн хаалгыг хааж, бохирын цооногийг таглана.

Гэр хорооллын нүхэн жорлон, бохирын цооногт дулааны улиралд сард нэг удаа, хүйтний улиралд гурван сард нэг удаа халдваргүйжүүлэлт хийнэ.

Хана, тааз, гишгүүрийг шүршиж халдваргүйжүүлнэ.

Аюулгүй ажиллагаа: Халдваргүйжүүлэлтийн бодисыг найруулах хэрэглэхийн өмнө зааврыг сайтар унших, зааврын дагуу найруулна.

Уусмал бэлтгэхдээ хамгаалах өмсгөл, бээлий маск, нүдний шил хэрэглэнэ.

Санамсаргүй тохиолдлоор хуурай бодис, бургиж нүд рүү орсон бол урсгал, бүлээн усаар сайтар угаах, амьсгалын замаар орсон бол цэвэр агаарт гаргах шаардлагатай.

- Найруулсан уусмалыг тухайн өдөртөө хэрэглэнэ.
- Бодисыг хүүхдээс хол байлгана.
- Хуурайгаар хэрэглэхийг хориглоно.

Гаалийн хяналтын талбайд байгаа ашиглалтаас гарсан нүхэн жорлонг “Нүхэн жорлон, угаадасны нүх” MNS 5924:2015 стандартын дагуу доорх шаардлагын дагуу ариутган булах шаардлагатай.

- ✓ Буулгах шаардлага. Дахин ашиглах боломжгүй жорлон, угаадасны нүхний бохирдсон хөрсийг зайлуулж халдваргүйжүүлэлт хийн эрүүл хөрсөөр дүүргэж ариутгана.
- ✓ Нэвчилттэй жорлон, угаадасны нүхний эзлэхүүний 90 хувь нь ялгадас, хөлдүүсээр дүүрэх үед жорлонгийн бүхээгийг зайлуулан нүхийг 30см-ээс багагүй зузаан шороогоор булна. Ялгадас доош шингэж хөрс суулт өгөх бүрд шороогоор нэмж булна.
- ✓ Жорлон, угаадасны нүхэн жорлон доторх ялгадас, угаадсыг соруулж халдваргүйжүүлэлт хийсний дараа эрүүл хөрсөөр дүүргэж булна. Ялгадас, угаадсыг зөвшөөрөгдсөн цэгт зохих журмын дагуу зөөж зайлуулна.
- ✓ Жорлон, угаадасны нүхэн доторх ялгадас, угаадсыг соруулж халдваргүйжүүлэлт хийсний дараа эрүүл хөрсөөр дүүргэж булна. Ялгадас, угаадсыг зөвшөөрөгдсөн цэгт зохих журмын дагуу зөөж зайлуулна.
- ✓ Жорлон, угаадасны нүх байсан суурин дээр мод, зүлэг тарьж хөрсийг нөхөн сэргээнэ.

Хүснэгт 10. Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх зардал

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн	Хог хаягдлын цэгийг стандартын дагуу байгуулах	Талбайн нийт ахуйн хаягдал	ш	1,000.0	1	1,000.0	2023	UCS 1701A:2022 “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” хотын стандарт “Хог хаягдлын тухай” хууль, “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага” (БОАЖС-ын 2018 оны А/443 дугаар тушаал). “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам” “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага” MNS 5924 : 2015
		Төслийн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг зайлуулах		удаа	40,000	12	280.0	2023	
		Эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулах, сунгуулах, гэрээний дагуу ачуулах	Талбайд	-	-	-	-	2023	
2.	Шингэн хаягдал	Нүхэн жорлонг “Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага” MNS 5924 : 2015 стандартын дагуу байгуулах,	Талбайд	ш	200,000	3	600.0	2023	
3.	Ариутгал, халдваргүй-жүүлэлт хийх	Хатуу шингэн хог хаягдлын цэгүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх	Хог хаягдлын цэг	Удаа	20,000	Улиралд 1 удаа	4*20 = 80.0	2023 он	
4.		Одоо ашиглаж байгаа нүхэн жорлонг ариутгал халдваргүйжүүлэлт хийн булшлах	Нүхэн жорлон	ш	500.0	3	1,500.0	2023 он	
Нийт							3,460.0		

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
1. АГААРЫН ЧАНАР⁴								
1.	Агаарын чанарын (NO ₂ , SO ₂ , CO, PM _{2.5} , PM ₁₀) шинжилгээ хийлгэж байх	- Гаалийн хяналтын талбайн салхины зонхилох чиглэлийн дагуу	Жилд 1 удаа	1	38,500.0+36,000.0 техникч томиллолт	74.5	Нэг удаагийн хэмжилтээр 2 ажиглалтыг нэг мөр хийнэ.	<ul style="list-style-type: none"> - MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, - MNS 17.2.5.12 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, - MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга - MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ - MNS 5919 : 2008 Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын баус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга
2. ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ⁵								
1	Хөрсний ерөнхий шинжилгээ (Агрохими,	- Ашиглалтад өртөөгүй талбай/фон цэг/	Жилд 1 удаа/ 9 сард/	1	25.0	25.0	Шинжилгээний үр дүнг мэргэжлийн хөндлөнгийн	MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт”,

⁴ Байгаль орчин хэмжилзүйн төв лабораторийн агаарын шинжилгээний үнээр тооцов.

⁵ “Нарт ШУҮН КОНСОЛТИНГ” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторийн үнээр тооцов.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
	Механик бүрэлдэхүүн)						лаборатори байх нь зүйтэй.	MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 5850:2019 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ”,
2	Хөрсний бохирдлын шинжилгээ /11 элемент/	<ul style="list-style-type: none"> - Хогийн цэгийн орчим - Нүхэн жорлонгийн ойролцоо - Авто зогсоол 		3	25.0	75.0		
УСНЫ ЧАНАР								
1	Усны ерөнхий химийн үзүүлэлтүүд	Хэрэглээний усаа зөөврөөр хангадаг худаг	2023 онд 1 удаа	1	49.0	49.0	Шинжилгээний үр дүнг мэргэжлийн хөндлөнгийн лаборатори байх нь зүйтэй.	MNS 4586:98 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүйн байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага. Чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS 6148:2010 Усны чанар. Газар доорх усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Усны бохирдлын хяналт хийх/ 54 элемент/	Хэрэглээний усаа зөөврөөр хангадаг худаг	2023 онд 1 удаа	1	78.0	78.0		
Хяналт мониторингийг хэрэгжүүлэх жилийн гүйцэтгэлийн зардал, мян.төг								301.5

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан	тайлбар
			2023 он					
			I	II	III	IV		
1.	Байгаль орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын харилцааг зохицуулах дотоод дүрэм, журамтай болох	“Говийн алтан гулдмай” ХХК - аас зохицуулах			+	+	Удирдах албан тушаалтан + асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Шаардлагатай тохиолдолд удирдах дээд байгууллагат асуудлыг тавьж шийдвэрлүүлэх хүртэл арга хэмжээ авч хэрэгжүүлж болно.
2.	Дотоодод боловсруулсан дүрэм журмуудыг мөрдүүлэх, хяналт тавих	“Говийн алтан гулдмай” ХХК - аас зохицуулах			+		Гаалийн хяналтын талбай хариуцсан эрхлэгч	
	Нийт	-						

АРВАН ХОЁР. 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 13. Оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	Зардлын агуулга	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцах албан тушаалтан	Холбогдох зардал	Зохион байгуулах газар
1	Орон нутгийн удирдлага, хөндлөнгийн хяналт, олон нийт	Хэвлэмэл эсвэл цахим тайлан	Төлөвлөгөөт ажлын тайлан, биелэлтийн үр үр дүн, дараа жилийн БОМТ	2023 оны 10 сарын 15-ний дотор	“Говийн алтан гулдмай” ХХК -ийн асуудал хариуцсан мэргэжилтэн	200.0	Ханбогд сумын нутгийн удирдлагын ордон
2	Төслийн харьяаллын багийн ИНХ, төслийн талбай орчмын оршин суугчид	Мэдээллийн илтгэл, хэвлэмэл танилцуулга эсвэл цахим тайлан				200.0	Төслийн талбай
БОМТ-г тайлагнах ажлын зардлын дүн, мян.төг							400.0

БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДАЛ

Төслийн үйл ажиллагаанд БОМТ-г хэрэгжүүлэхэд 2023 онд нийт 19,071.5 төгрөгийн зардал тооцогдож байна.

Хүснэгт 14. БОМТ-г хэрэгжүүлэх нийт зардал

№	БОМТ-ний хүрээнд хийх ажлын багц	Нийт тооцсон зардал, мян.төг	Нийт дүнд эзлэх хувь
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	2,410.0	12.6
2	Орчны тохижилт, ногоон байгууламжийн төлөвлөгөө	12,500.0	65.5
3	Түүх соёлын өвийг хамгаалах	-	-
4	Осол эрсдэлээс хамгаалах төлөвлөгөө	-	-
5	Хог хаягдлын менежментийг зохион байгуулах	3,460.0	18.1
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	301.5	1.6
7	Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ	-	-
8	БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	400.0	2.1
Нийт зардал		19,071.5	100

Хавсралтууд

1. Газрын гэрчилгээ

МОНГОЛ УЛС

**АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН
ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН
ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар 000009811

_____ / 3618641 /-д
(аж ахуйн нэгж, байгууллагын нэр) (регистрийн дугаар)

Сумын Засаг даргын захирамж _____ -ын 20 18 оны 02 сарын 05 өдрийн A/34 тоот
(нийдвэр гаргагч)

шийдвэрийг үндэслэн _____
(аймаг, нийслэл) (сүлж, дүүрэг) (баг, хороо)

Цагаан хад _____ хаягт
(судалсны нэр) (хяналтын дугаар, тоот)

байрлах, нэгж талбарын 4601008735 дугаар бүхий 100000.0 / 10 / м.кв /га/ газрыг
Гаалийн хяналтын талбай _____ зориулалтаар
15 жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн Э-112000027
дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.


**ГАЗРЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН
БАЙГУУЛЛАГА / УЛБАН ТУШААЛТАН**

СУМЫН ГАЗРЫН ДААМАЛ

ТАМГА / ТЭМДЭГ _____ / _____ /
(сүлж) (нэр)

19 05 23
20 оны сарын өдөр

2. Газрын кадастр



3. бохир ус соруулах, тээвэрлэх гэрээ

- 4.2. Хэрэглэгчийн ая тухтай орчныг бүрдүүлэх зорилготой бохир ус соруулах, тээвэрлэх ажлыг найдвартай тасралтгүй гүйцэтгэх үүрэгтэй.
- 4.3. Том машины тос тосолгоо, нефть болон химийн ямар нэгэн бодис зэрэг цэвэрлэх байгууламжид хор хөнөөл учруулж болзошгүй бохир усыг соруулахгүй байх эрхтэй.
- 4.4. Бохир усны машин, тоног төхөөрөмжид эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд засварлах, урьдчилан сэргийлэх үүрэгтэй.
- 4.5. Хангагч байгууллага зөвхөн ажлын цагаар ажиллах бөгөөд бохир соруулах дуудлагыг 48 цагийн өмнө авсан байх, бохир ус соруулсан тэмдэглэгээ, хөтөлгөөг сар, өдрийг тодорхой хөтөлж Хэрэглэгчээр гарын үсэг заавал зуруулан 1 хувийг Хэрэглэгчид өгөх үүрэгтэй.
- 4.6. Хэрэглэгчээс бохир соруулах дуудлагыг 48 цагийн өмнө авснаас хойш ажлын 3 өдрийн дотор ирж бохир ус соруулах, тээвэрлэх ажлыг гүйцэтгэнэ. Хэрвээ хангагч талд бохир ус соруулах, тээвэрлэхэд саад гарвал дуудлага авсан өдөртөө нөгөө талд хариу мэдэгдэнэ.
- 4.7. Хангагч байгууллага нь Хэрэглэгч байгууллагын бохир усыг Цагаан хад суурьшлын бүсээс Ханбогд сум дахь өөрийн цэвэрлэх байгууламжид тээвэрлэж буулгана.
- 4.8. Хангагчийн буюу түүний ажилтны буруутай үйлдлээс болж Хэрэглэгчийн эд хөрөнгөд ямар нэгэн хохирол үүссэн тохиолдолд учирсан хохирлыг тооцож Хангагч тал хариуцан барагдуулна.

Тав. Хэрэглэгч байгууллагын эрх үүрэг

- 5.1. Хэрэглэгч нь Монгол Улсын Иргэний тухай хууль, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль тогтоомж, дүрэм журамд заасан эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ.
- 5.2. Хэрэглэгч нь үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллагатай бохир ус соруулах гэрээ байгуулснаар бохир ус соруулах эрх үүснэ.
- 5.3. Хэрэглэгч нь бохир соруулах цооног нүхэндээ хог хаягдал, царцаг бөглөрдөг зүйлсийг хийхгүй байх шаардлагатай ба эдгээрийг бий болохоос хамгаалах тор, шүүр зэргийг байршуулах үүрэгтэй.
- 5.4. Хэрэглэгч ажил үүргээ гүйцэтгэж байгаа ажилтныг эзэмшил газартаа саадгүй нэвтрүүлж, сорогч автомашин ажил гүйцэтгэхэд тохиромжтой аюулгүй зогсоол гаргасан байна.
- 5.5. Хэрэглэгч бохир соруулах дуудлагаа 80828272 дугаарт ажлын цагаар өгөх бөгөөд дуудлагыг 48 цагийн өмнө өгч байна.
- 5.6. Хэрэглэгч талын буруутай үйлдлээс болж бохир соруулах машин тоног төхөөрөмжид хохирол үүссэн тохиолдолд Хэрэглэгч тал засвар үйлчилгээ болон бусад хохирлыг бүрэн хариуцна.

Зургаа. Гэрээ дүгнэх болон цуцлах журам

- 6.1. Хангагч байгууллага нь бохир ус соруулсан тэмдэглэгээ, хөтөлгөөг сар, өдрийг тодорхой хөтөлж Хэрэглэгчээр гарын үсэг заавал зуруулах бөгөөд тухайн баримтыг Хэрэглэгч, Хангагч байгууллага тус бүр 1, 1 хувийг хадгална.
- 6.2. Энэ зүйлийн 6.1-д заасан баримтыг үндэслэн Хэрэглэгч, Хангагч нар нь сар бүрийн 15-ны дотор өмнөх сарын бохир ус соруулж, тээвэрлэсэн байдлыг дүгнэж, тооцоо нийлсэн актыг үйлдэж байна.

6.3. Гэрээний аль нэг тал энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлдэггүй тохиолдолд гэрээний талын санаачингаар нутагша.

Долоо. Хариуцлага

- 7.1 Хэрэглэгч сар бүрийн 25-ны дотор багтаан тогтвортой төлөх бөгөөд уг хугацаанд төлбөр хийн эсгүй бол хугацаа хожимдуулан хоног тутамд тологдоогүй төлбөрийн үнийн дүнгийн 0.5%-тай гэнцэх хэмжээний алданыг Хангагчид толно.
- 7.2 Хэрэглэгчээс бөхир соруулах дуудлагыг 48 цагийн өмнө авснаас хойш ажлын 3 өдрийн дотор ирж бөхир ус соруулах, гэнцрэх ажлыг гүйцэтгэгүй бол хугацаа хэрүүрсэн хоног тутамд гүйцэтгэл өгөх үүргийн үнийн дүнгийн 0.5%-тай гэнцэх хэмжээний алданыг тогдуула.
- 7.3 Гэрээгээр хүтээсэн үүргээ биелүүлдэггүйгээс учирсан хохирлыг тэм буруутай талын нөгөө талд тодох үүргтэй.

Найм. Маргаан шийдвэрлэх

8.1 Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд эвний журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН АРБИТРААР эцэслэн шийдвэрлүүдэх бөгөөд арбитрын ажиллагаанд тус арбитрын маргаан хянан шийдвэрлэх журмыг баримтлана.

Ес. Гэрээний хавсралт

- 9.1 Гэрээнд хавсралтаар хавсаргасан дор дурдсан зүйлүүд нь гэрээний салшгүй хэсэг болно. Үүнд:
 - 9.1.1 Хангагчийн тусгай зөвшөөрлийн хуулбар;
 - 9.1.2 Талуудын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
 - 9.1.3 Талуудыг төлөөлж гэрээ байгуулах этгээдийн бичиг баримтын хуулбар, хэрэв Гүйцэтгэх захирлаас оор этгээд байгаа тохиолдолд илгэмжлэл.

Арав. Бусад зүйл

- 10.1 Энэхүү гэрээ нь Хангагч, Хэрэглэгч байгууллагуудын эрх бүхий албан тушаалтны баталсан өдрөөс эхлэн хүчин тогтоодор болох бөгөөд гэрээг 2 хувь үйлдэн талууд тус бүр 1:1 хувийн хадгална.
- 10.2 Талууд энэхүү гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын эрх бүхий албан тушаалтан баталснаар хүчин тогтоодор болно.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХАНГАГЧИНИГ ТӨЛӨӨЛЖ

“ХАНДИС” ХХК-ийн захирал

ЦИДЭРЯРИН

Утас: 80828272




ХЭРЭГЛЭГЧИНИГ ТӨЛӨӨЛЖ


“ГОВИЙН АЛТАН ГУЛДМАЙ” ХХК-ийн захирал

М. АРАВ



4. энгийн хог хаягдлын гэрээ


БАТЛАВ:
“ХАНШИЖИР ГОВЬ” ХХК-НИЙ ЗАХИРАЛ
ХАН ШИЖИР ГОВЬ /Б.Бүжидэлгэр/


БАНГАВ:
“ГОВИЙН АЛТАН ГУЛДМАЙ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ /Х.Амарсүх/

ХОГ ХАЯГДАЛ АЧИЖ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ
№22/ 057

2022 оны 04 сарын 14 өдөр Цагаанхад, Өмнөговь аймаг

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Нэг талаас Ханшижир говь ХХК /цаашид Гүйцэтгэгч гэх/, нөгөө талаас 3618641 тоот регистрийн дугаартай, Өмнөговь Далайзадгад 3-р баг Далан 17 байрлах, “Говийн алтан гулдмай” ХХК /цаашид Захиалагч гэх/-ийн Өмнөговь аймаг, Ханбогд сум, Цагаанхад суурьшлын бүсийн Кемпийн ахуйн хог хаягдлыг тээвэрлэхээр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.
- 1.2. Энэхүү гэрээ нь 2022 оны 04-сарын 05-ны өдрөөс 2022 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 1.3. “Хог хаягдлын тухай” хуулийн хүрээнд Цагаанхад суурьшлын бүсийн нутаг дэвсгэрийн Кемпийн ажигтад болон ААН байгууллага үйлдвэрлэлийн хог хаягдлыг тээвэрлэх, түүнтэй холбогдсон гарсан төлбөр тооцооны асуудлыг шийдвэрлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.4. Гэрээний үнийн дүнг хоёр тал харилцан тохиролцон тогтоосон болно.

Хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 2.1 Гүйцэтгэгч нь захиалагчтай байгуулан гэрээнд заасан хуваарийн дагуу ААН байгууллага, кемпийн хог хаягдлыг саадгүй ачиж тээвэрлэх үүрэгтэй.
- 2.2 Тээвэрлэлт саатнаас хог хаягдал хуримтлагдсан бол графика зааснаас бусад цагаар нэмэгдэл хүч зохион байгуулан ачуулах арга хэмжээг авна.
- 2.3 Гарч буй ахуйн хогийг тогтмол цагт цуглуулах, мөн барилга барих, буулгах, засварлах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгжийн хог хаягдлын төлбөрийг толүүлсний дараа тээвэрлэнэ.
- 2.4 Хог хаягдлыг тээвэрлэх аюулгүй ажиллагсаны шаардлагыг хангасан, битүүмжилсэн зориулалтын тээвэрийн хэрэгсэлтэй байх.
- 2.5 Гүйцэтгэгч нь ажил үйлчилгээ үзүүлсний төлбөрийг ААН, байгууллага болон иргэд, захиалагч байгууллагуудаас шаардах хэрэгтэй.
- 2.6 Захиалагч тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулаагүй тохиолдолд хог хаягдлыг ачиж тээвэрлэхгүй байх эрхтэй.
- 2.7 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

- 3.1 Захиалагч тал “Хог хаягдлын тухай /шингэчилсэн найруулга” хуулийг мөрдөж ажиллана.
- 3.2 Тухайн ААН, байгууллага, барилга байгууламжаас гарсан хог хаягдлыг зөвхөн тогтоосон хогийг цэг буюу бункерт хийж ачуулах хэрэгтэй.

1

5. Аюултай хог хаягдлын гэрээ

БАТЛАВ: "ГОВИЙН АЛТАН ГУЛДМАЙ" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ М.НАРАНГАРЯВ

БАТЛАВ: "АЛТАН ОРШИХУЙ ГРУПП" ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Р.БАЯРБАТ

ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС, ТОСОЛГООНЫ ШИНГЭНИЙ ХАЯГДАЛЫГ
ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ ГЭРЭЭ
№.

2023 оны 3-р сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү Техникийн хаягдал тос, тосолгооны шингэн хаягдалыг хүлээлгэн өгөх гэрээ /цаашид "Гэрээ" гэх/-г нэг талаас Өмнөговь аймаг Ханбогд сум, Хайрхан 5-р баг Цагаан Хад байрлах 3618641 тоот регистрийн дугаар бүхий "Говийн Алтан Гулдмай" ХХК /цаашид "Үүсгэгч" гэх/-ийг төлөөлж Захирал албан тушаалтай Мягмарсүрэн овогтой Нарангаряв нөгөө талаас Улаанбаатар хот Багахангай дүүрэг 1-р хороо химийн гудамжинд байрлах 5537266 регистрийн дугаартай "Алтан Оршихуй Групп" ХХК /цаашид "Боловсруулагч" гэх/-ийг төлөөлж Хангамж, борлуулалтын менежер албан тушаалтай Д.Ариунмөрөн нар /хамтад нь "Талууд" гэх/ Монгол улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, байгаль орчны нөлөөлөх байдалын багц хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг үндэслэн дараах нөхцөлтэйгээр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү гэрээний зорилго нь Үүсгэгч нь өөрийн үйлдвэр, уурхайгаас гарах техникийн ашигласан тос, тосол, гидрийн шингэн болон бусад тосолгооны шингэний хаягдал /цаашид "Хаягдал тос" гэх/-ийг холбогдох дүрэм, журмын дагуу цуглуулах, хадгалах, тээвэрлэн Үүсгэгчээс Боловсруулагчид шилжүүлэх, Боловсруулагч нь хүлээн авах, устгахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хаягдал тос нь хог хаягдлын ангилалын төрлөөр аюултай хог хаягдлын А зэрэглэлд \БОАЖЯСайдын А/349 тоот кодчилсон жагсаалтанд\ багтсан байгаль орчинд хор аюулын чанартай шингэн хог хаягдал юм.
- 1.3. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ байгаль орчны бохирдол гаргахгүй, галын аюулгүй байдлыг бүрэн сахиж, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлд үйл ажиллагаа явуулах шаардлагатай.
- 1.4. Энэхүү гэрээнд талууд нөгөө талынхаа хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж үйл ажиллагаандаа хуулийг дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нууцыг чанд хадгалах зарчмыг баримтална.
- 1.5. Энэхүү гэрээний Хавсралт №1-т Үүсгэгчийн хаягдал тос цуглуулах, хадгалах үйлдвэр, уурхайн жагсаалт, сард гарах хаягдалын хэмжээ, төрлийг бүрэн тодорхойлж хавсаргах бөгөөд энэхүү хавсралт нь гэрээний салшгүй нэгэн гол хэсэг байна.

Хоёр. Гэрээний хугацаа

Гэрээ нь 2023 оны 3-р сарын 22-ний өдрөөс 2023 оны 12-р сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хүчинтэй байна.

- 1.2 Гэрээний хугацааны хэрэгжилтийг хоёр тал харилцан үйл ажиллагаа зохистой явагдсаныг хянан, дүрэм журмын биелэлтийг дүгнэж, сунгах саналыг шийдвэрлэнэ.
- 1.3 Гэрээний хэрэгжилт бүрэн хангагдсан дүгнэлтэнд дараах зүйлийн биелэлтийг дүгнэнэ. Үүнд:
 - 1.3.1 Энэхүү гэрээний баталгаанд Үүсгэгч нь өөрийн эзэмшлийн талбай дээрх хог хаягдалын кодчилсон жагсаалтын 13-р бүлгийн аюултай хаягдалын төгрөгт тооцон жилд нийлүүлэх хаягдалаас хамааран 800.000 "Гэрээний үүргийн баталгаа" болгож Боловсруулагчид байршуулах.
 - 1.3.2 Үүсгэгч нь гэрээний хугацаанд хаягдал тосыг Боловсруулагчид тушаасаны дараа "Гэрээний үүргийн баталгаа"-нд хаягдал тосны ус, механик хольц бохирдлын хэмжээг нийт тосны 20%-нд 100 төгрөгт тооцон, суутгана.
 - 1.3.3 Боловсруулагч нь Үүсгэгчээс гэрээний тохиролцсон хугацаанд хаягдал тосыг хүлээн аваагүй ямарч тохиолдолд "Гэрээний үүргийн баталгаа"-г буцаан олгохгүй байх, хүлээн авсан хаягдал тосонд үүссэн механик хольц,

6. Ус ашиглах гэрээ

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2023 оны 06 сарын 02-ны өдөр

Дугаар *03/05*

Улаанбаатар хот

Энэхүү УС АШИГЛАХ ГЭРЭЭ-г нэг талаас худаг эзэмшигч КИ 84121671 регистрийн дугаартай Баньд овогтой Баярцэнгэл /цаашид “Ашиглуулагч” гэх/ түүнийг төлөөлж Б.Баярцэнгэл нөгөө талаас “Говийн Алтан Гулдмай” ХХК /цаашид “Ашиглагч” гэх/ түүнийг төлөөлж Захирал М.Нарангарав нар 2023 оны 06-р сарын 02-ний өдрийн 01 дугаартай ус ашиглуулах дүгнэлтэй 2023 оны 02-р сарын 14 -ний өдрийн ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн дараах нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээ нь сайн дурын үндсэн дээр байгуулагдсан бөгөөд гэрээний бүх зүйл, заалттай нэг бүрчлэн бүрэн танилцаж хүлээн зөвшөөрөгдсөн байх, хүсэл зорилгоо бүрэн илэрхийлсэн байх зарчимд тулгуурлагдсан болохыг хоёр тал харилцан хүлээн зөвшөөрөв.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Өмнөговь аймаг Ханбогд сум 3-р баг цутгалан Жавхлант 331 тоот хаягт орших Ашиглуулагчийн өмчлөлийн худгаас Ашиглагч нь өөрийн хэрэглээний цэвэр усыг худалдан авч, төлбөрийг саадгүй төлнө.
- 1.2 Гэрээний хугацаа: Ашиглагч, ашиглуулагч нь ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг гурван жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1 Ус ашиглах зориулалт, хэмжээ хоногт 5 тонн машинаар 5 удаа Цагаан хад суурьшилийн бүсрүү ус тээвэрлэнэ

Худгийн нэр : Баруун замт

Солбицол: 42° 46' 56" 107° 24' 12" Гүн 61 Ундарга л/сек 2,4 усны тоолуур байхгүй

2.5. Ус ашигласны нэгж төлбөрийг харилцан тохиролцож төлнө

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Ашиглуулагчийн эрх, үүрэг

3.1.1. Ашиглуулагч нь худаг ашиглахтай холбоотой холбогдох зөвшөөрөлийг / Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл г.м/ холбогдох эрх бүхий байгууллагаас авсан байх,

3.1.2. Ашиглуулагч нь усны нөөц ашигласны төлбөр, татвар, хураамжийг холбогдох эрх бүхий байгууллагад төлнө.

3.1.3. Ашиглуулагч нь худгийг бохирдол, хомсдолоос хамгаалах зорилгоор эрүүл ахуйн болон хориглолтын бүсийн хил, заагийг мэдэгдэхүйцээр тэмдэгжүүлэх, хамгаалах.

3.1.4. Ашиглуулагч нь Ашиглагчийн үйл ажиллагаанд шаардлагатай байгаа цэвэр усаар саадгүй хангах,

3.2 Ашиглагчийн эрх үүрэг

3.2.1 Ашиглагч нь хүлээн авсан цэвэр усны төлбөрийг Ашиглуулагчид саадгүй төлөх,

3.2.2. Ашиглагч нь цэвэр усыг өөрийн хэрэгцээгээр, зүй зохистой хэрэглэх,

3.2.3. Ашиглагч нь худгийн ойр орчныг бохирдуулахгүй хог хаягдал хаягүй байх,

3.2.4. Ашиглагч худгаас ус авахдаа цэвэр усыг асгахгүй байх,

Дөрөв. Бусад

4.1. Энэхүү гэрээ нь Монгол хэл дээр 2 эх хувь байх бөгөөд хоёр талын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, дугаар авч, тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

4.2 Гэрээтэй холбогдон гарах аливаа мэдэгдэл, шаардлага, захидлууд нь бичгийн хэлбэрээр байх бөгөөд доорх хаягаар хүргэсэн үед тухайн баримтыг хүлээн авсанд тооцно.

4.3.Талуудын тохиролцооноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.4. Гэрээг Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд байгуулсан бөгөөд түүнд заасны дагуу ойлгож, тайлбарлагдана.

4.5. Гэрээнд заагаагүй бусад асуудлыг Монгол улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.

4.6. Гэрээний хугацаанд болон түүнээс хойш үүсэх маргаантай асуудлыг хоёр тал харилцан эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Тохиролцоонд эс хүрсэн тохиолдолд асуудлыг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЭНЭХҮҮ ГЭРЭЭНИЙ БҮХ ЗҮЙЛ ЗААЛТТАЙ БҮРЭН ТАНИЛЦАЖ, ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН БӨГӨӨД ЯМАР НЭГЭН МАРГААНГҮЙ БОЛОХЫГ БАТЛАВ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Баньд овогтой Баярцэнгэл

Гарын үсэг: 

Харилцах утас: 88110922

Ус ашиглагчийг төлөөлж:

Говийн Алтан Гулдмай ХХК

Гарын үсэг: 

Харилцах утас: 77727755

